

ХОТОГОЙДЫН НОЁДЫН ТАЛААРХ ЗАРИМ АСУУДАЛ

Ц.Цэрэндорж

Улаанбаатар их сургууль.

Өгүүллийн товч утга: Хотогойдын ноёдын нэр цол, угсаа гарал, Хотогойдын түүхийн зарим асуудлыг хөндөн үзэж, өөрийн саналыг дэвшүүлэхийг оролдсон болно.

Түлхүүр үг: Хотогойд, Лувсан тайж, Бэсүдийн Бүүвэй.

1. Лувсан тайж- цол уу, нэр үү?

Хотогойдын Алтан хан хэмээгчдийн сүүлчийнхийг буюу Эринчинийг манай түүхийн ном зохиолд Лувсанринчен, Лувсан тайж гэх мэтээр нэрлэж ирснээс үзвэл Лувсан хэмээхийг түүний оноосон нэр гэж үзэж байгаа нь илэрхий байна. Харин сурвалж бичгүүдэд Ринчин сайн хун тайж¹, Сайн хун тайж² гэж бичсэн нь үзэгдэнэ. “Зарлигаар тогтоосон Гадаад Монгол Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир”-т түүнийг “Лувсан тайж Эринчин”³, Оросын архивын бичиг баримтад Лобжан-царевич, Лобзан Ирдений-тайча, Лобзан Сайн-Контайчи, Лобчан Ирдений-тайчин, Логзан, Лоджан-хан, Лоджан-царевич, Лозан-тайша, Лоузан⁴ гэх зэргээр тэмдэглэж байжээ. Ер нь орос зүгийн бичиг баримтуудад монголын ноёдыг нэрээр нь бичихээс илүүтэй цолоср нь бичсэн нь элбэг байдаг билээ. Бидний бодлоор Лувсан тайж гэдэг нь түүний оноосон нэр бус цол бололтой. Учир юун хэмээвээс ихэнх сурвалжуудад түүнийг Лувсан тайж буюу Лувсан тайж Эринчин, Эринчин гэж бичсэнээс бус Лувсанринчин гэж бичсэн нь ховор билээ. “Илтгэл шастир”-т “... Норов үгүй болсны хойно түүний хөвгүүн Ваншуг залгамжлаад мөнхүү Засагт хан хэмээн нэрийдвэй. Омбо эрдэнэ үгүй болсны хойно түүний хөвгүүн Эринчин залгамжлаад Лувсан тайж хэмээн нэрийдвэй.”⁵ гэж тэмдэглэжээ. “Илтгэл шастир”-ын хятад эхэд үүнийг 號 hao гэж тэмдэглэсэн байх бөгөөд 號 гэдэг ханз нь “цол” гэсэн утгатай⁶ аж.

Харин “нэрийдэх” гэдэг үгийг 叫名 jiàomíng гэсэн ханзаар тэмдэглэдэг⁷ байжээ. Тиймээс Лувсан тайж хэмээх нь Засагт хан, Түшээт хан гэдэг шиг цол гэж бид үзэж байгаа юм. Лувсан тайжаас Оросын хаанд илгээсэн захидлын тамганы дардас нь “Сайн оюут шашныг сахигчийн тамга”⁸ гэсэн үгтэй бөгөөд “Сайн оюут” гэдэг нь Лувсан хэмээх түвэд үгийн орчуулга болохыг бид сайн мэднэ. Хотсгойдын ноёд бурханы шашныг идэвхийлэн дэмжиж, дэлгэрүүлж байсныг тухайн үеийн бичиг данс, сурвалжид тодорхой тэмдэглэн үлдээжээ. Эээр Засагчийн 16-р (1659) онд Жибзундамба хутагтыг (Өндөр гэгээн) “Өлзийт цагаан нуур хэмээх газар залж, Жалханз эхлэн долоон хошууны ноёд шар хар бүгдээр ном сонсоод баруун аймгийн лам нар ноёдод цол хайрлажухуй.”⁹ гэж сурвалжид тэмдэглэжээ. Анхдугаар Жалханз хутагт бол Лувсан тайжийн дүү билээ. Тиймээс Жибзундамба хутагтаас ном сонссон ноёдын дотор Эринчин байсан нь лавтай бөгөөд “баруун аймгийн лам нар ноёд” гэдэг нь Халхын баруун гарын лам ноёдыг хэлж байгаа бололтой тул энэ үед Эринчинд “Лувсан

¹ Byamba-yin Asarayci neretu (-yin) teike (Эхбичигийн судлагаа) Тэргүүн дэвтэр. Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, хэвлэлд бэлтгэсэн Цэвэлийн Шагдарсүрэн, и СӨН ГЮ (lee seong-gyu). УБ., 2002. 71-р тал

² Gangyu-a-yin urusqal, öbür mongyol-un arad-un keblei-ün qoriy-a, kókeqota, 1981.136-р тал

³ jarliy-iyar toytayaysan yadayadu mongyol qotung ayimay-un wang güng-üd-ün ilekkel šastir. 67-р дэвтэр, 1а тал

⁴ Материалы по истории русско-монгольских отношений (1654-1685), составитель Г.И.Слесарчук, М., 1996.

⁵ jarliy-iyar toytayaysan yadayadu mongyol qotung ayimay-un wang güng-üd-ün ilekkel šastir. 61-р дэвтэр, 86-9а тал

⁶ Tabun jüyil-ün üsüg-iyer qabsuruysan manju ügen-ü toli bičig (degedü debter), bezejing, 1957, 1526-р тал

⁷ Мөн тэнд.

⁸ Д.Өлзийдолгор. Монгол улсын төрийн тамга. УБ., 1999, 250-р тал

⁹ Galdan. Erdeni-yin erike, УБ., 1960, 93-р тал

тайж” хэмээх цолыг хайрласан байж магадгүй юм. Харин зарим тохиолдолд Лувсан хэмээх үгийг нь орчуулан, Сайн оюут буюу Сайн хун тайж гэж нэрлэдэг байсан бололтой. Ер нь өгүүлэн буй үед түвэд цолтой ноёд цөөнгүй байснаас гадна түвэд цолыг орчуулан хэрэглэж байсан явдал ч бий. Тухайлбал: Түмэнхин сайн ноёны наймдугаар хөвгүүн Данжин, цол Банжур хэмээмүй... арван хоёрдугаар хөвгүүн Хүүхэн, цол Базар хэмээмүй¹ гэх зэргээр сурвалжид тэмдэглэжээ. Хотогойдын Лувсан тайжийн хөвгүүнийг “Асрагч нэртийн түүх”-нд Даш хатан баатар² гэснийг “Илтгэл шастир”-т Өлзийт хатан баатар³ хэмээн орчуулан нэрлэсэн байна.

Лувсан тайж Эринчиний цол нэр хоёрыг нийлүүлж, Лувсанринчин болгосон нь түүнийг өөр хүнтэй эндүүрэх шалтгаан болсныг бид хойно өгүүлэх болно.

2. Бэсүдийн Бүүвэй бэйл гэдгийг нягтлахуй

Хотогойдын Гэндэн дайчингийн үр болгосон хөвгүүн Бүүвэйг Бэсүдийн Бүүвэй хэмээдэг гэж манай судлаачид тэмдэглэсээр иржээ. Доктор С.Пүрэвжав Хотогойдын бэйл Бүүвэйг Бэсүд овогтой⁴ гэж үзсэнийг профессор А.Очир шүүмжлээд, Бүүвэй бэйлийг бэсүд бус, Боржигин овогтой байсныг тогтоожээ⁵. Бид Хотогойдын Бүүвэй бэйл яагаад Бэсүд овогтой гэж үзэгдэх болсон талаар өөрийн саналыг дэвшүүлэхийг оролдъё. Бидний олж үзсэнээр Хотогойдын Бүүвэй бэйлийг Бэсүдийн Бүүвэй гэдэг хэмээн анх доктор С.Пүрэвжав өөрийн бүтээлдээ дурджээ⁶. Гэтэл сурвалж бичгүүдийг шүүж үзвэл, Гэрсэнзийн дэд хөвгүүн Ноёндой хатан баатарын угсааны Бүүвэй гэдэг ноён ХҮII-ХҮIII зууны зааг үед амьдарч байжээ. Ноёндой хатан баатарын хөвгүүн Төвд хатан баатар, түүний ахмад хөвгүүн Хонгор сэцэн жонон, түүний гуравдугаар хөвгүүн Цэрисгив сайн ахай дайчин, түүний хөвгүүн Цагаан барс хэмээх Тэнгэри тойн, түүний ахмад хөвгүүн Бүүвэй ажээ. Бүүвэй Энх-Амгалангийн 27-р (1688) онд Манжид дагаар орсонд, 30-р онд хошууны бэйс өргөмжлөөд засаг хавсаргажээ⁷. Түүний өвөг дээдэс үе улиран Бэсүдийг мэдэж байсан бөгөөд сурвалжид “... Бүүвэй. Язгуур баруун гарын Бэсүдийн Цагаан барс ноён билээ⁸” гэж тэмдэглэсэнээс үзвэл түүний өргөмжилсөн овог нь Бэсүд байсан ажээ. Харин Хотогойдын Бүүвэй бэйлийн өргөмжилсөн овог нь Хотогойд байсныг түүний дөрөвдүгээр дүү Шагжийн угсааны Цэдэвдорж “...миний овог хиюд, өргөмжилсөн овог Хотогойд”⁹ гэснээс тодорхой мэдэж болно. Хотогойдын бэйл Бүүвэй нь Гэндэн дайчингийн дүү гүн Сунгаравын хөвгүүн бөгөөд Гэндэнд үрчлэгдэж, түүний хэргэмийг залгамжилсан¹⁰ билээ. Гэтэл доктор С.Пүрэвжав энэхүү Бүүвэйг Хотогойдын Бүүвэй бэйлтэй нэр ижил тул андуурсан нь тодорхой байна.

Доктор С.Пүрэвжав “Хотгойдын угсаа гарал ба түүхийн асуудалд” зохиолдоо энэ мэтээр нэр ижил хүнийг нэг хүн хэмээн ташаарсан нь цөөнгүй аж. Тухайлбал, “Илтгэл шастир”-ын 79-р дэвтэрт (Алашаны өөлд аймгийн шастирын хураангуй) гарч буй Ойрадын Эрдэнэбаатар хун тайжийн дүү Цөхүр убашийн 5-р хөвгүүн Лувсанринчинийг Хотгойдын Лувсан тайж Эринчинтэй андуурснаас

¹ jarliy-iyar toytayaysan yadayadu mongyol qotung ayimay-un wang güng-üd-ün ilelkel šastir. 69-р дэвтэр, 3а-3б тал

² Byamba-yin Asarayci neretu (-yin) teluke (Эхбичигийн судлагаа) Тэргүүн дэвтэр. Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн хэвлэлд бэлтгэсэн Цэвэлийн Шагдарсүрэн, и сөн гю (lee seong-gyu). УБ., 2002. 71-р тал

³ jarliy-iyar toytayaysan yadayadu mongyol qotung ayimay-un wang güng-üd-ün ilelkel šastir. 67-р дэвтэр, 2а тал

⁴ С.Пүрэвжав. Хотгойдын угсаа гарал ба түүхийн асуудалд (XVI-XIX зуун), УБ., 1970, 48-р тал

⁵ А.Очир, Ж.Гэрэлбадрах. Халхын Засагт хан аймгийн түүх. УБ., 2003, 113-р тал

⁶ С.Пүрэвжав. Хотгойдын угсаа гарал ба түүхийн асуудалд (XVI-XIX зуун), УБ., 1970, 48-р тал

⁷ jarliy-iyar toytayaysan yadayadu mongyol qotung ayimay-un wang güng-üd-ün ilelkel šastir. 64-р дэвтэр, 8-9-р хуудас

⁸ А.Очир, Ж.Гэрэлбадрах. Халхын Засагт хан аймгийн түүх. УБ., 2003, 413-р тал

⁹ А.Очир, Ж.Гэрэлбадрах. Халхын Засагт хан аймгийн түүх. УБ., 2003, 417-р тал

¹⁰ Ц.Сономдагва. Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт (1691-1997), нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ., 1998, тал 292-р тал

нэлээд олон алдаа гаргажээ. "Илтгэл шастир" –т "... Цөхүр убаши хэмээгч Галданы бага арга мөн. Түүнээс таван хөвгүүн төрөвэй. Ахмад хөвгүүн Бага банди, хоёрдугаар хөвгүүн Ананд, гуравдугаар хөвгүүн Лувсан хутагт, дөрөвдүгээр хөвгүүн Луузан, тавдугаар хөвгүүн Лувсанринчин. Галдан өөрийнхүү хорсголоор Багабандийг хударгалан алж Цөхүр убаши, Лувсанринчин тэнийг барьж хорьвой. Багабандийн хөвгүүн Ханд хэмээгч Хоролийн зээ мөн"¹ гэж тэмдэглэжээ. Энэхүү Лувсанринчин Энх-Амгалангийн хорин тавдугаар (1686) онд 1000 илүү харьяатыг авч Хөхнуурт ирж, Манжид дагасныг Хотгойдын Лувсан тайжийг Энх-Амгалангийн 25-р онд манжид дагасан² хэмээн бичсэнээс гадна "Өөлдийн Лувсанринчин" гэдгийг Хотгойдыг өөлдтэй холбох сэжим болгосныг хожмын судлаачид тэр бүр анзаараагүй бололтой. Үнэн хэрэгтээ Лувсан тайжийн Баруун зууд аваачсан албатын тоо хэд байсан нь тодорхойгүй. Лувсан тайж Эринчинийг Ойрадын Галдан бошогт Халхын Засагт хан Цэнгүнд шилжүүлэн өгсний дараа тэрбээр Засагт хантай эвдрэлцсэн ажээ. Цэнгүн "түүнийг хуучин найман засагт тооцвой хэмээн өөрийн биеийг дагалдаж алба барьтугай хэмээвэй. Эринчин урьдын ялаас айхын тул Оросыг цуглаж Цэнгүнийг байлдсугай хэмээхийг Цэнгүн мэдээд өөрийн хөвгүүн Шарыг зарж, түмэн илүү цэрэг аваачуулаад Эринчинийг хударгалан баривай. Эринчин дагалдаагаар оргож бас Өөлдөд эрээр одсоны учирт Цэнгүн түүний өрх аман морь малыг бүрнээ" хураан авчээ³. Сурвалжид ийнхүү албат ардыг нь "бүрнээ хураасан" гэж тэмдэглэсэн тул Лувсан тайж Эринчин Өөлдөд цөөн тооны албат авч одсон бололтой. Засагт хан Цэнгүн Лувсан тайж Эринчинтэй эвдрэлцсэн нь дээр дурдсанчлан Лувсан тайж "Оросыг цуглаж Цэнгүнийг байлдсугай" хэмээснээс болсон гэжээ. Лувсан тайж Эринчин хамгийн сүүлчийн удаа 1679 онд Баадари Колочи-бакшийг Оросын элч Степан Тупальский-г дагалдуулан Цагаан хаанд элч болгон зарсан⁴ бөгөөд түүнээс хойш тэрээр Орост дахин элч зараагүй ажээ. Ийнхүү Оростой элч солилцож байсныг нь түүнийг Оросын тусламжийг авч, Засагт хан Цэнгүнийг довтлохоор зэхэж байна гэж үзсэн бололтой. Гэсэн хэдий ч Лувсан тайж Засагт ханы эсрэг тэмцэхээр Оросоос тусламж гуйсан баримтыг бид олж үзсэнгүй. 1681 онд Оросын хязгаарын эрх баригчдаас Лувсан тайжийн нутаглаж байгаа газар тодорхойгүй болсон⁵ тухай мэдээлж байжээ. Бодвол, тэр үед Лувсан тайж Засагт ханд цохигдсон тул сураг алдарсан бололтой. Засагт хан Цэнгүн Лувсан тайжид өс санаж, түүнийг Оросын тусламж авах гэж байна хэмээн шалтаглаж довтолсон байхыг ч үгүйсгэх аргагүй. Ер нь Лувсан тайж Засагт ханы эсрэг хөдлөхөөр зэхэж байсан, тэр хэрэгтээ Оросын зүгээс тусламж гуйж байсан эссэн талаар цаашид нягтлан судлах хэрэгтэй.

Лувсан тайжийг хэдэн онд Манжид дагаар орсон тухай "...Галдан лугаа сэв болж Баруун зуугаас (Баруун зууд гэхийг ташаарсан бололтой-Ц.Ц.) зайлаар одоод Далай ламд түшиж суужухуй. Энх-Амгалангийн гучин нэгдүгээр (1692) онд дагаар" ирсэн гэж сурвалжид тодорхой тэмдэглэсэн буй. Үүнээс үзвэл, тэрбээр Хөх нуурт биш, харин Баруун зуу (Түвэд)-д очиж Далай ламыг түшин суусан нь тодорхой байна. Харин судлаачид түүнийг Хөх нуурт очиж суусан гэж бичсэн нь үндэс муутай бөгөөд энэ нь Лувсан тайжийг Өөлдийн Лувсанринчинтэй андуурснаас үүдсэн бололтой.

¹ Jarliy-iyar toytauaysan yadayadu mongyol qotung ayimay-un wang güng-üd-ün ilelkel šastir. 79-р дэвтэр, 7а-7б тал

² С.Пүрэвжав. Хотгойдын угсаа гарал ба түүхийн асуудал (XVI-XIX зуун), УБ., 1970, 45-р тал

³ Jarliy-iyar toytauaysan yadayadu mongyol qotung ayimay-un wang güng-üd-ün ilelkel šastir. 61-р дэвтэр, 22а-22б тал

⁴ Н.П.Шастина. Русско-монгольские посольские отношения XVII века. М., 1958, 102-103-р тал

⁵ Материалы по истории русско-монгольских отношений (1654-1685), составитель Г.И.Слесарчук, М., 1996, стр. 383

Бас доктор С.Пүрэвжав Бүүвэй бэйлийн хөвгүүн Бандийг (Хотогойдын Шадар ван Чингүнжавын эцэг) Бэсүдийн Бүүвэй бэйсийн дүү Бандитай эндүүрснээс Чингүнжавын эцэг Бандийг "...багадаа Лувсанринчинд (еөрөөр хэлбэл Хотгойдын Лувсан тайж Эринчинд гэсэн үг-Ц.Ц.) олзлогдож Хөх нуурт сууж байсан... Хотгойдууд Бандийг Ахай дайчин гэдэг байсан"¹ хэмээн ташаа тэмдэглэжээ. Мөн Халхын Ахай дайчин Бандийг Зүүнгарын Цөхүр убашийн хөвгүүн Лувсанринчин, түүний ач Ханд нарт уулгалагдсаныг Хотогойдын Лувсан тайжид уулгалагдсан мэтээр ташаарчээ.

Дээр өгүүлснийг хураангуйлбал Хотогойдын Бүүвэй бэйл, Бэсүдийн Бүүвэй гэдэг нь хоёр өөр хүн бөгөөд зарим судлаачдын анзааргагүй байдлаас тэднийг нэг хүн гэж үзэх болсон ажээ. Гэхдээ "Бэсүдийн Бүүвэй" гэдэг нь хотогойдын доторх бэсүд овогтонтой холбоотой байхыг үгүйсгэхгүй. Угтаа Бэсүдийн ноён Бүүвэй Танну онну уулын захад нутаглаж² байжээ. Танну онну уул гэдэг нь Тагнын нуруу мөн бололтой. Тийм бөгөөс бэсүд нар Хотогойдтой зэргэлдээ нутаглаж байгаад, өмнө тийш одоогийн Говь-Алтай аймгийн нутагт шилжихэд тэдний зарим нь уугуул нутагтаа үлдэж, улмаар Хотогойдын дунд шингэсэн байж болох талтай. Тэдгээр бэсүд нар өөрийн язгуурын ноён Бүүвэйг дурсдаг байсан нь түүнээс арай сүүл үеийн Хотогойдын Бүүвэй бэйлтэй эндүүрэгдэж, Хотогойдын Бүүвэй бэйлийг Бэсүдийн Бүүвэй гэж нэрлэдэг болсон байхыг ч үгүйсгэх аргагүй юм.

Abstract: In this article, the author has paid attentions to some issues on the origin and history of Qotuuyuid and put forward some new proposals.

Ном зүй

1. Byamba-yin Asaragūci neretū (-yin) teūke (Эхбичигийн судлагаа) Тэргүүн дэвтэр. Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн хэвлэлд бэлтгэсэн Цэвэлийн Шагдарсүрэн, И Сөн Гю (Lee Seong-Gyu). УБ., 2002.
2. Gangū-a-yin urusqal, öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, kökeqota, 1981.
3. jarliy-iyar toytayaysan yadayadu mongyol qotung ayimay-un wang gūng-ūd-ün ilekkel šastir.
4. Материалы по истории русско-монгольских отношений (1654-1685), составитель Г.И.Слесарчук, М., 1996.
5. Tabun jūyil-ün üsüg-iyer qabsuruysan manju ūgen-ū toli bičig (degedü debter), begejing, 1957.
6. Д.Өлзийдолгор. Монгол улсын төрийн тамга. УБ., 1999.
7. Galdan. Erdeni-yin erike, УБ., 1960.
8. С.Пүрэвжав. Хотгойдын угсаа гарал ба түүхийн асуудалд (XVI-XIX зуун), УБ., 1970.
9. А.Очир, Ж.Гэрэлбадрах. Халхын Засагт хан аймгийн түүх. УБ., 2003.
10. Ц.Сономдагва. Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт (1691-1997). нэмж засварласан 2 дахь хэвлэл. УБ., 1998.
11. Н.П.Шастина. Русско-монгольские посольские отношения XVII века. М., 1958.

¹ С.Пүрэвжав. Хотгойдын угсаа гарал ба түүхийн асуудалд (XVI-XIX зуун), УБ., 1970, 49-р тал

² jarliy-iyar toytayaysan yadayadu mongyol qotung ayimay-un wang gūng-ūd-ün ilekkel šastir. 64-р дэвтэр, 86 тал